

Дэлхий дахинд

- Улс төрийн тэмдэглэл – гуравдугаар хэсэг -



Сүүлийн вед барууны болон хэт барууны үзэлтнүүд (тэжээвэрүүд) Орос дахь Кавказтай холбоотой зорчилт асуудлуудыг “Кавказын ард түмний эсрэг Оросын явуулсан геноцид” гэж нэрийдэх нь элбэгшив. Бvүр XIX

зууны Оросын хаант Засгийн бодлогыг ч “геноцид” болгож хувиргав бололтой. Оросын бүрэлдэхүүнд байсан, оор хоорондоо ялгаа зороотэй байдал бүхий үндэстэн ард түмнүүдэд барууны иргэншлийг нэвтрүүлэх, баруунчилах вйл явцын гол зорилго нь энэ мэт ямар ч шаардлагагвй, нотолгоо баталгаагвй цуу мэдээг дэлгэрүүлж, дэлхий нийтэд буруу ойлголт огоход чиглэгдсэн мэт. Нягтлаад үзэх юм бол дурьдсан цаг вед үнэндээ Орос

(
Зовлолт
)

улстай холбоотойгоор нэг ч ард түмний газар нутаг, үндэстний бүрэн бүтэн байдал алдагдаагвй явж ирсэн богоод, дийлэнх үндэстний хvн амын олонхийг уугуул үндэстэнүүд нь бүрдүүлсэн хэв шинжтэйгээр аж торж ирсэн. Тухайн цагт барууныхан Индайнчуудын амьдралыг тvймэрдэн, шатааж, Тасмануудыг таслан хааж, Негрүүдтэй наймаалцсан бол харин Оросууд маш олон янзын угсаатан, ард түмнүүдийг бичиг үсэгтэй болгож, эрүүл мэндийг нь хамгаалж, тэдгээрт вйлдвэрлэх хvчнийг хогжүүлсэн богоод тэд

чухам Зовлолтийн үед л хэн хүнгүй шагшин магтах түүвшинд хогжин цэцэглэж чадсан. Тэгвэл энэ үйл явцыг оноодор барууныхнаас бусад улс үндэстнүүд юу гэж харж байна вэ? Оросын түүхэнд үнэхээр геноцид ажиллагаа явагдаж онгорсон гэж харна гэж үү?

Орчин үеийн хойт Америкийн Индианчууд бараг л гэгээрэл боловсролгүйгээр амьдарч байгаа тухай АНУ-ын болон бусад барууны хэвлэл мэдээллээр мэдээлж байна. Гэсэн ч Индианчуудын дунд бүүр барууны хүмүүст гайхаш торүүлэм ондор гэгээрэлд хүрсэн хүмүүс бий. Тэдний нэг нь Индиан омгийнхний их жолоодогч Дакота юм. Эрт үеэс үүнийг нийтэд мэдэгдэхгүй байхыг чухалчилахаас гадна Америк ардчилалд цохилт болохоос болгоомжилон, түүнийг Кагахи үндэстэн хэмээн нэрийдэхийг тулган хүлээлгэсэн байдаг. Түүний хамгийн ойрын нохор, хамтран зүтгэгч Леонардо Пелтиера амьдралынхаа сүүлчийн одрийг хүртэл Америкийн фашизмын эсрэг эсэргүүцэн тэмцсээр дууссан. Канадын сэтгүүлч Арджил Тернер “Их удирдагч”-тай ярилцаж, нийтлэл, мэдээлэл бэлтгэсэн байдаг бөгөөд тэдгээрийн нэгэнд удирдагч Америкийн хэд хэдэн их сургуулиудад нууц нэрээр суралцаж, боловсрол олж авсан тухай нь үгүүлсэн бий. Одоо энэ нь хойт Америкийн оргон уудам эх газрын хаана нь ч ил гаргаж болохгүй, нууц мэдээлэл хэвээр байна.

Тэрээр ардчилсан гэгдэх барууны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тухайн үед нь “удирдагч”-тай ярилцсан ярилцлага болоод түүний талаар ямар нэг мэдээллийг хэзээ ч нийтлэж байгаагүй. Гагцхүү хэзээ хойно түүний гар бичмэл болон дуу бичлэгт үлдсэн ярианаас л түүх болгон нийтлэх болсон юм.



- Түүх сонирхдог хүний хувьд ажиглаж байхад орчин цагийн олон улсын харилцаанд урьд олно нь огт байгаагүй сонин үзэгдэл гарч байгааг харах боллоо. Жишээ нь барууны хаант засаглалын нолоонд ямар нэг хэмжээгээр ортсон улс үндэстнүүд хэн нэгэн маань хэрвээ дайнд ялж чадахгүй бол гарцаагүй сүйрэн унана гэсэн монхийн айдаст дотроосоо автсан хэвээр байна. Энэ зохистой үзэгдэл мон үү? Яг ийм явдал Индианчуудад тохиолдсон. Хэрвээ АНУ 150 жилийн олно Индиан омгийн тэргүүнүүдийн дунд яс хаяж, маргаан үүсгээгүй бол зарим талаар биднийг (Индианчуудыг) худалдан авч чадахгүй байсан бөгөөд ялалт Индианчуудын талд байх байсан. Бас түүрүүхэн Ирак, Ливий Югаславд болж онгорсон хэрэг явдал одоо Сирид орнож буй үйл явцыг хар л даа. Түүгээр ч зогсохгүй одоо АНУ барууны ертөнцийг оорийн хараа хяналтанд бүхлээр нь

авахын тулд Кавказад хвртэл тулж очиж, тэндэх Оросын нолоолтэй шоргооцолдох санаа агуулж байх шиг надад санагдаж байна. Үүний гол сэдэл нь Кавказ болон Туркэд морголдоон үүсгэх явдал. Хэдэн жилийн омно би Адыгенээс ирсэн Оросын эрдэмтэнтэй уулзсан юм. Тэр эрдэмтэн бол Индианчуудыг Туркуудтэй угсаа нэгтэй гэсэн үзлийг баримтлагч талын хүн байсан. Энэ тухайгаа илэрхийлсний дараа тэр Адыген дахь Черкесүүдийн амьдрал ямар байгаа талаар ярьсан ба бид хоёрын дунд нэлээн халуун яриа орносон юм. Тэгээд бодож үзэхэд “агуу Манитууд яагаад тийм байх гэж, бид торол угсаа нэгтэй учир бүгд адил эрх чолоогоо алдаж, гачигдал, зовлонд нэрвэгдсэн хэрэг үү? Засаглалыг ийм байдлаар явуулахаас оор аргагүй байсан гэж үү? Тэр газраас цааш хаа хвртэл бидний урьдны /эрт цагийн

/ маань газар нутаг оршин байгаа юм бол. АНУ-ын зэвхий дээрэмчид тэндэхийн газар оронд л хорхойсон зүтгэж байгаа байх нь ээ? гэсэн асуудлууд гарч ирж байгаа юм.

Миний ажиглаж байгаагаар ойрхи дорнодод маш сонирхолтой үйл явц орнож байна. Сирий дэх морголдоонд Оросууд хутгалдан орсны дараагаас ээлж ёсоор ИГИЛ-ын (Исламын улс

)А гэгч гарч ирэв. Оросод тэднийг нэвтрүүлэхийг хориглосон бол харин Турк, Саудын Арави болон зарим нэг улсад тал бүрээр дэмжин оогшүүлэх боллоо. Туркууд Кавказид дайны түймэр дэгдээхийг оролдож байна. ААА Карабахын асуудлаар ямар ч нотолгоогүй, огт хэрэггүй зүйлээр оролдон, тэндэхийн нохцол байдлыг хурцатгахын толоо зүтгэж байгаагаас энэ нь илэрхий харагдаж байгаа юм. Тэрбээр анзаарагдаж байгаагаар бол “шинэ Османы эзэнт улс” байгуулах тосол бий болгохоор зэхсэн ба Орос улс Сирид ажиллагаа явуулж эхэлсний дараагаар ойрхи дорнотыг бүрмөсөн нураах гэсэн моноох санаархалаа тэвчих болсон. Эрдагоны хараа хяналт Кавказ руу чиглэгдэх болов. Исламын байгууллагуудад элдэв торлийн дэмжлэг үзүүлэх замаар олон үндэстний бүс нутагт бий болж буй морголдоонийг одоон турхирах нь тэдэнд сонирхолтой байх шиг. Тэрбээр Орос улс ч хүлээж авахаас аргагүй гэж тооцоолжээ. Туркийн еронхийлогчийн “түрэмгийллийн толовлогоо”-нд ортсон онцгой газар нь Адыгенск. Тэрээр “миний Адыген найз Орамзамезийг надад ог” гэж хэлсэн удаа би богоод энэ мэт үзэл хандлагаа тэр “Кавказийн асуудал” гэсэн нэр томъёогоор хучиж байгаа юм.ААА Дараа нь манай хүмүүстэй уулзахдаа Кавказын ард түмэнд атаархаж байгаагаа чухалзуулан, “Орос Кавказын түвхийн асуудлыг авч үзсэн маань Кавказийн газар нутаг хүн амыг үгүй хийх гэсэн биш, харин манай улс үндэстэний адил зэрэгт авч үзэж, тодий хэмжээнд хүргэх л гэсэн хэрэг, Орос улс урьдын “геноцид ажиллагаа”-ныхаа толоо гэмших ёстой” гэх мэтийг огүүлсэн.

Гэтэл хэрвээ тийм бол, - одоо цагт чухам хэн маань дэлхий дахинд болж онгорсон үй олон түрэмгий үйлдэл, хомроглон устгах /геноцид/ ажиллагааны түвхийг мартагнуулахыг хичээж байгааААА билээ гэдэг асуудал гарч ирнэ. Хиросима Нагасакагийн цомийн

цохилт геноцид ажиллагаа биш гэж үү? Саяар тоологдох Вьетнамчуудыг химийн зэвсгээр устгасан нь бас геноцид ажиллагаа биш үү болох гэж үү? Баруунд хэдэн арав, зуун саяар тоологдох хүмүүсийг золиослосныг оорсдоо устсан гэж хэн ч хэлэхгүй биз ээ.

Тэгвэл “Черкесийн асуудал” гэж юу юм бэ? XIX зууны дунд хагаст Черкес омгийнхон тэдний холбоотон байсан Шамиль болон Имамачуудтай нэгдэн, Оросын эсрэг самуун дэгдээсэн. Үүний үр нолоо нь тэд бараг бүгдээрээ, тэр ч атугай хаант засаглалтайгаа хамт дарагдан, устсан явдлаар дуусав. Энэ мэт янз бүрийн үймээн самууны голоор Черкесүүдийн 96 хувь нь үрэгдэж үгүй болсон байдаг. Черкесүүдийг байгалийн жамаар устсан гэж хэн ч нотлохгүй л дээ. Оороор бол Индианчууд болон Кавказийн ард түмний хувьд аль аль нь адилхан гунигт хувь заяанд дайруулсан улс. Болсон процесс нь ийм богоод бидний хувьд бодит түүхийг гуйвуулан худал ярих ёс суртахуун байхгүй. Шамилийн ходолгооний үндсэн хүч нь хожим Авари болон Чеченчүүд болж хувирсан гэдгийг хэн хүнгүй мэднэ. Дараа нь 1859 оны наймдугаар сард Шамиль олзлогдож, улмаар цээрлүүлэгдсэн ч тэр ард түмнийг мордож мошгох явдал болоогүй. Тэд оршин тогтнож байсан богоод үүнийг одоо тайлбарлах шаардлагатай аваас тусгайд нь авч үзэх хэрэгтэй байх ...

Харин АНУ болохоор тэднийг Оросын орон нутгуудаар тархаан шингээсэн гэж үздэг. Тэд уулынхны дунд холилдон орсон нь үнэн л дээ. Гэвч одоо тэднийг угсаатныхаа хувьд хаа нэгтээ оршин тогтнож байгааг тодорхойлох аргагүй болсон. Хэзээ ч томоохон овог угсаатан байгаагүй тэд онгорсний туршид зовхон “хэсэгхэн үүлний тасархай” мэт, дурсагдах тодийд л үлдэж хоцорчээ. Гэвч үүнийг “хомроглон устгагдсан” гэж үзэж болох уу? гэдгийг уншигч та ч бодож үзэгтвн. Нэг л мэдэхэд цоорч үгүй болсон Черкесүүдийн тухайд тийм хорон, нууц түүх агуулагдаж байгаа гэж үү...?

Түүхийн баримт сохвол: Черкес (язгуур нэр нь адыге)-чүүд Адыговын ард түмний нэгэн хэсэг, одоогийн Оросын газар нутаг болох Карачаев – Черкеси бол тэдний үндсэн газар нутаг. 60.8 мянган хүн амтай богоод тэдний 50.2 мянга нь Карачаев – Черкесийнхэн юм. Оороор бас тэднийг Адыге, Кабардинчууд буюу Адыгейчүүд ч гэдэг байв. Карачаев – Черкесид арван долоон Бүгд найрамдах улс оршин тогтнодог. Бас ойрхи дорнод тэдний тасархай бий богоод тэд

XI

Х
зууны хоёрдугаар хагасд тийш шилжин суурьшжээ. Хожим Адыге болон Абхазуудыг бүхэлд нь “Черкес” гэж нэрийдэх болсон богоод заримдаа оороор, Хойд Кавказынхан ч гэх нь бий. Хойд Кавказын оршин суугчид түүхийн тодорхой цаг үед бүгд Оросод нэгдсэн юм. Түүхийн салбарын мэргэжлийн судлаачдаас гадна бүр мэргэжлийн бус хүмүүс ч Москвагийн

(
хаант засаг

)
бодлогын үрээр ганц ч улс үндэстэн устаж, үгвй болоогүй гэж үздэг. Оросын түүхэнд тэнд буй омог угсаатнуудыг толгойлогчгүй, засаглалгүй болгох, цус урсган хядах ажиллагаа ер гарч байгаагүй бөгөөд харин ч улс үндэстнийх нь хувьд дэмжин тэтгэх бодлого явуулж ирсэн.

Тэгвэл “геноцид” гэж юу гэсэн нэр томъёо юм бол? Улс төрийн ухаанд омог угсаатнаар нь болон шашин шүтлэгээр нь хомроглон устгах гэдэг ойлголт байдаг. Оросын Засаглалын түүхэнд Черкесүүдтэй эсвэл оор ямар нэг омог, угсаатнуудтай харилцахдаа тийм зорилго тавьж байсан явдал огт байхгүй. Гэтэл яагаад барууныхны хэн нь ч бодит баримтуудад анхаарал хандуулахгүй байна вэ? Барууныхны үзэл сурталд үргэлж л ямар нэг “гэм, зэм”-ийн толоо, үйлдсэн хэргийнхээ толоо гэмших тухай зохиомол ухагдахуун явсаар байдаг бөгөөд энэ чухам тэдний оорсдийнх нь үйлдсэн үйлийн үрээс улбаалан тархи мэдрэлд нь хоногшигхсон зүйл бололтой. АНУ болон түүний холбоотнуудын ажиллагаа юунд чиглэгдэж байна гэвэл эхлээд Грузинд явуулж буюу “Геноцид” буюу “Черкесүүд” хэмээн томъёолсон зохиомол үзэл санааны ходролгоон, улмаар “Черкесийн хатуу ширүүн явдал” гэгч зохиомол зүйлээ хүмүүст давтан хоногшуулах замаар оноогийн ноцол байдлыг Орос улсын эсрэг эргүүлэх л сонирхолтой байгаа. Үнэндээ бол тэд Черкесийн эмгэнэлийн тухай санаа зовж байгаа гэж үү? Энэ бол огтхон ч үнэмшилгүй асуудал юм.



XIX зууны дундуур болж онгорсон Кавказийн зорчилт асуудлын үед, эсвэл түүний дараа тэд ийшээ гар сунгах нь байтугай санаа тавьсан уу гэвэл огт үгүй шүү дээ. АА Шамили йнхантай, Имамачуудтай тэмцэж асан хэдэн арван жилийн дотоод тэмцэлдээнийг Оросод “Крымын” мон “дорнод Европын үйл явдал” гэж нэрэлдэг, гэтэл Кавказыг үүнд хамааруулж үзэх нь учир утгагүй зүйл юм. Англи болон Туркууд нутгийн ард түмнийг Оросын эсрэг идэвхтэйгээр одоон хатгаж байна. Эхний ээлжинд тэд хойд Кавказын баруун хэсгээр, хаана Черкесүүд амьдарч байсан байна тэр нутгуудын хүн амд нолоо үзүүлж, одоон турхирахыг оролдож байна. 1856 оны 7 сарын дундуур Крымын дайны тогсгол ойртож байх үеэр уг дайн Британий Засгийн газарт ач холбогдолгүй тогсохоор болоод ирмэгц, тэд бэлтгэгдсэн мэргэжлийн цэргийнхнийг Английн цэргийн холог онгоцоор зоон авч ирж, Кавкази дахь уулынхны хил хамгаалах отряднуудын дунд байршуулан, нутгийнхнийг зэвсэглэж, одоон турхирах замаар Оросын эсрэг босгохоор оролдож байсан. Түүнчлэн тэндхийнхнийг Англи, Францын харъяат болохыг ятган уриалж эхэлсэн ба дараа нь энэ ажиллагаагаа Туркийн оршин суугчдын дунд бас явуулж байв. Энэ бол омог нь Англи, Франц, Испанчуудын зүгээс Индайнчуудтай харилцахдаа хэрэглэж байсан арга барил нь бөгөөд тэд Индайнны омгуудыг зэвсэглэж, ногоогийнх нь эсрэг одоон турхирах аргаар оор хооронд нь тэмцэлдүүлэн, хүчийг нь мохоож авсаныхаа дараа хагаралдан тэмцэлдэж буй тэдний газар нутаг дээр дайны гал дэгдээж, хонгохон эзэлж авсан түүхтэй.

XIX зууны туршид Орос болон Османы эзэнт улсууд бvх талаар харилцаатай байсан ба хvчирхэгжиж хаягаа тэлэх санаа агуулсан вeд нь тийнхvв дайны гал ассан байдаг. Эл вeд Турк Английн талыг дэмжин Оросын фронтын ар талын нутгууд руу хvч хаях явдлыг даамжруулан оогшvлэх сонирхолтой байв. Ийм нохцол байдалд Орос улс дайнд ялах магадлал тун бага байсан. Гэсэн ч Орос ялалт байгуулсан богоод ялалтад хvргэсэн давуу чанар нь юу гэвэл тухайн вeд Оросын хаант Засаг байлдаж байгаа улсуудын болон дэлхийн улс орнуудын ар тал руу огтхон ч санаархаагvй юм. Тvвнчлэн Кавказын дайны хувьд хэзээ ч угсаатны хоорондын шинж чанартай байгаагvй. Үндсэн шалтгаан нь эрх мэдлээ булаалдсан эзэнт улсуудын морголдооноос вvдэлтэй байж, эхлээд Орос болон Османы эзэнт улсын хооронд орносон ба тvвнд Англи, Франц улсууд татагдан орсон юм. Ийм байдлаар салан тусгаарлах ходолгоон, зорчил морголдоонvвд эртнээс одоо хvртэл Кавказид орносоор ирсэн ба очигдор ч бас оноодор ч эмх замбараагvй, бутран сарнисан, сvйрэн доройтсон вймээн бужигнаан болсоор байна. Дашрамд хэлэхэд энэ нь эртний Орос дахь хvй олныг хамарсан ходолгоонvвдийн сэдэвт хамаарах ба АНУ-ын Олон улсын хогжлийн агентлагийн дэргэдэх Жеймстауны сан болон Европын холбооноос хамтран явуулсан “Черкесvвдийн асуудлаарх олон улсын эрдэм шинжилгээий хурал” дээр энэ вйл явцыг /процесс/ “Черкесийн хомроглон устгах ажиллагаа /геноцид/ “ хэмээн гуйвуулсан нэр томъёонд оноосон хэрэг.

Оросын засгийн газар хязгаар нутгуудад энх тайван тогтоох, суурьшил газрууд болон тvвний хvн амын тайван, амгалан байдлыг эрхэмлэх бодлогыг эн тэргvвнд тавьдаг богоод хэзээ ч цус асгаруулахыг урьтал болгодогvй билээ. Чухам ийм болохоор хязгаар дахь томоохон вндэстэн угсаатнууд Москвагийн Засгийн газрын харъяалалд байх нохцлийг таатайгаар дуулгавартай хvлээн зовшоордог. Гагцхvв уулынхны зарим хэсэг нь вvний эсрэг санаа бодолтой байдаг ба Англи болон Туркийн зvгээс тэднийг одоон турхирч, хагалан бутаргахыг санаархсаар байна. Тиймээс Оросын Засгийн газар хязгаар нутгийн вндэстэн, оршин суугчид болон Туркийн харилцааны тухайд хvч, анхаарал тавьж, хангалттай хугацаанд дуугvй байсан байр сууриа оорчлон, Кавказид бат бэх байдал тогтоохын тулд шаардлагатай арга хэмжээ авах хэрэгтэй болоод байгаа юм. Энэ асуудлыг цэрэг зэвсгийн замаар шийдвэрлэхийг ч вгvйсгэх аргагvй болсон гэж холбогдох газрууд вээж байгаа.

1860 оны зун нэгэн зориудын /кампант/ ажиллагаа эхэлсэн. Кавказын нурууны Лаба гол, Цагаан гол, Уруп голуудын урсгалын дагуух ой ховчийг сэтлэж зам тавьсан богоод тэнд шинэ суурьшлын бvсийг бий болгосон. Энэхvв вйл ажиллагааны вeэр ч, тvвний дараа ч уулынхны зvгээс эсэргvвцэл взvвлээгvй юм. Тэд бvгдээрээ л тvвнд сэтгэл ханамжтай байсан. Оросын Засгийн газраас уулын оршин суугчдын саналаар нутаг хувиарлан суулгаж байсан богоод хэн нь ч Туркийн харъяалал, захиргаанд орох хvсэлгvйгээр тэндээ аж торохийг илvвд вэсээр ирсэн. Индианчууд ч гэсэн тэр вeдээ бас хэн нь ч тэнд, энд суурьшина гэж санал тавиагvй байдаг. Гэтэл зориудаар вймээн вvсгэн, амар тайвныг

нь алдагдуулах явдал бол уугуул ард түмнийг хайр найргүй устгаж буй энгийн жишээ юм. Үнэхээр тухайн үед АНУ маш харгис, араатнаас ч долоон дор авирлан Индианчуудын бүгдийнх нь эсрэг хомроглон устгах /геноцид/ аж иллагаа явуулсан. Үр дүнд нь сая, сая уугуул Индианчууд устаж үгүй болсон билээ.

“Дээд зэргийн

/

геноцид

/

ажиллагаа” гэж чухам үүнийг л хэлэх байх.

«Абердинский Субботний Пионер» (Aberdeen Saturday Pioneer) сонины 1891 оны дугаарт тус сонины залуу редактор, хожим нь “Страна Оз” хэмээх зохиол бичиж, Америкийн сонгодог зохиолчдын нэг гэгдэх болсон

Лаймен Фрэнк Баум

гэгч бичихдээ “..манай аюулгүй байдлын гол шаардлага бол Индианчуудыг бүгдийг хомроглон устгах явдал. Тэд зууны туршид үржиж олшрох тусам бидний иргэншилд садаа болно. Газар шорооны торхтэй, мал адгуус мэт энэ зэрлэгүүдийг улам ихээр шахаж цоорүүлэн, арчиж устгаж дуусгах хэрэгтэй. Энэ бол хожим нь манай чадвар тааруухан командлагчтай цэрэг, иргэнийхний аюулгүйн баталгаа болно. Онгорсон жилүүдэд улаан арьстнуудын балгийг арилгахын тулд явуулсан очүүхэн ч гэсэн хүчин зүтгэлийг чамлах аргагүй юм...” гэсэн байдаг. Оросын уран зохиолын сонгодогуудаас хэзээ ч энэ мэт ямар нэг ард түмнийг устган сүйрүүлэхийг уриалсан зэрлэг балмад үг үгүүлбэрийг олж үзэхгүй. Энэ бол Оросын эсрэг үзэл гэгчийн бодит түүхийг гэрчлэх хангалттай нотолгоо, барууны хэвлэл мэдээллийн мон чанарыг илчилсэн маш тодорхой баримт болж байна. Дашрамд хэлэхэд оноодор Адыгейний ард түмнийг хамгаалагчын дүрд тоглохоор элсэн суралцаж буй Туркийн элитүүдийн олонх нь

XIX

дүгээр зуунд хойд Кавказийн байлдааны ажиллагаанд оролцож байсан Оросын армийн офицерүүдийн үр сад гэдгээсээ ичмээр. Түүх үргэлж л ийм шинж торхтэйгээр давтагддаг ажээ.

Черкесүүдийн хувьд Индианчуудаас ялгаатай нь гэвэл Кавказийн нурууны үй түмэн хавцал, салаа, нугчаанууд дунд оршдог. Тэрээр үйл явцыг гурван хувилбараар авч үзэж болох юм.

Үүнд:

- **Оросын харъяаллыг хүлээн авсан явдал:** - Энэ тохиолдолд ямар ч тулгалт, залхаан

цээрлүүлэлт байгаагүй. Тэд торолх газар нутгаа орхисон. Харин түүний үрээр хорш зэргэлдээх Казахууд тэр нутагт түрэн орж суурьшсан. Гарт нь зэвсэг бариулбал тэд моноох түрэн орж ирэгсэдтэй дайлалдах, эсвэл үхэх гэсэн хоёрхон замаас оор сонголтгүй байсан бөгөөд Оросын арми үүнд аль нэг талд нь хүч тавихаас зайлхсхийсэн юм.

- **Хоёр дахь хувилбар бол тэд Туркэд цагаачлах:** - Эл асуудлаар Орос улс тэднийг бас л албадаагүй. Зөвхөн саад хийхгүйг эрхэмлэсэн ба харин тухайн үед тэд тэнгисийн чанадаас даллан дуудсан Турк, Английн урхинд оорсдоо явж орсон. Индианчуудыг аймаглан устгасан шиг тийм харгис явдал энд огтхонч байхгүй байхад ямар “геноцид ажиллагаа”-ны тухай яриа гаргаад байгаа нь ойлгомжгүй байгааг уншигчид анзаараа байх. Орос улсын хувьд Черкесийг золиослосон зүйл үнэхээр үгүй бөгөөд харин Англи, Туркууд Кавказад янз бүрийн аргаар нохцол байдлыг хурцатган даамжруулж байгаа. Кавказын эзэнт улсын үед Орос улс байдлыг намжмал, тайван болгохын тулд яаралтай арга хэмжээ авч байсан тэр бодлого л одоо дахин үргэлжилж байна. Тухайн үед тэд Балканы хойг болон Армян дахь христос шашинтнуудын газар нутгийг оорсдийн эзэмшилд оруулах

“Турк –

Мусульманы төлөвлөгөө”

гэгчийг хэрэгжүүлэхээр зүтгэсэн ба түүнийг таслан хаахын тулд Оросын цэрэг Казакын суурьшил болон Туркийн түвшмэгүүд болох олон зуун суурьшигчдын зүг хөдлөж, оршин суугчдын дунд багагүй арга хэмжээ авсны нэг нь Оросын цэрэгт элсэгчдийг татвараас бүрэн чолоодсон явдал байв. Үүний үр дүнд Оросын арми тэр дариудаа хагас сая Черкесүүдээр хүчээ сэлбэв. Оросын Засгийн газар ийнхүү сонирхолтой тактик хэрэглэснээр Кавказ дахь самууныг үтэр түргэн бохийлгон дарж чадсан ба хорш улсууд болон суурьшигчид нь оорсдоо халуун цэгээс нутгийнхныг гаргах ажиллагаанд зориулан холог онгоцоо хэрэглүүлэх санал тавив. Оросын холог онгоц хологлон аюулгүй газарт дайжиж буй суурьшигчид Турк болон Английн одоон хатгалагад автахаас шулуухан татгалзаж эхэлсэн юм. Туркийн флот тэр хүмүүсийг хүчээр түрж дийлсэнгүй. Үүний үр дүнд Хар тэнгисийн эрэг хавиар Кавказаас дүрвэж очсон олон мянган хүмүүсийн суурьшил үүссэн. Түүнтэй зэрэгцээд газрын дундад тэнгист дүрвэж хүрсэн хэсэг бүлэг ард түмнийг одоо Европчууд ямар гаралтай улс болохыг нь ялгаж чадахгүй гайхацгаадаг ч явдал бий.

Тэгвэл одоо Кавказынхныг тийнхүү дайжуулан аврах боломжгүй бөгөөд тэнд чухам хэчнээн хүмүүс үхэлтэй нүүр тулгарч байгааг ч мэдэх аргагүй. Туркэд яаралтай товлорүүлж буй дүрвэгсдийн лагериудад тийшээ очихыг үүссэн хүмүүсийг хүлээн авах хүчин чадал үгүй болж, хүүхдийн зан авирын оорчлолт, үхэл хагацал нэлэнхүйд нь нүүрлэх болов. Черкесийн дүрвэгсдийг энэ хэцүү адармаат зам руу түлхэж буй явдалд хэмжээ хязгаар үгүй мэт. Тэгвэл энэ байдалд Орос улс буруутай гэж үү? Дүрвэн цагаачлагчдын урсгал хэзээ саарахыг тосоолшгүй бөгөөд тэнд тус улсын хүн амтай зэрэгцэн, уулынхны суурьшил бий болж байна. Чухамдаа одоо Адыгейчүүдийг тэнд шилжин суурьшиж байна гэж хэлэхэд ч буруутамгүй болжээ.

Орос дахь Черкесүүдийн толоолол болох Орзамез надад хэлэхдээ: “Чухамдаа одоо Орос улсад суурьшин амьдарч буй Черкесүүд энэхүү аз завшааныхаа үнэ цэнийг мэдэрч байна” гэсэн билээ. Османы үед шилжүүлэн зоох үеэр Оросын нутаг дэвсгэрт очиж, улмаар Оросын Засгийн газрын харъяалалд орсон Черкесүүдийн хувьд хязгаар нутаг дахь хогжин цэцэглэсэн хүчирхэг ард түмэн болон аж торж байна. Тэнд аж үйлдвэр, ходоо аж ахуй, худалдааг хөгжүүлэх аятай нохцлийг бүрдүүлснээс гадна хүүхэд, багачуудыг нь боловсролтой болгоход анхааран, сургууль нээж ажиллуулсан. Тэгвэл Америкийн Индайнчууд одоог хүртэл ийм нохцлийг мөроодсоор байгаа. Бас Турк, Англи, Америк улсууд Оросыг гутаан доромжлоход хамаг анхаарлаа товлорүүлж, Кавказын ард түмний цусыг асгаруулж байхаар, ядарсан ард түмнүүдийн толоо ийм арга хэмжээ авах хэрэгтэй шүү дээ.

Харин Черкесийн зарим ухаалаг хэсгийн толоологчид нь оноодор монгон орлоготой болох, түвнчлэн үр хүүхэд хойч үеийнхээ толоо Кавказ дахь Орос суурингууд руу тэмүүлж байна. Тэд эхний ээлжинд бичиг үсэгт боловсрох хэрэгтэй нь мэдээж богоод үүнийг хүсэж байгаа нохцолд тэднийг Орос сургуулиудад оруулан сургаж, боловсруулах, амьдралын нохцлоор хангах үүд хаалга нээлттэй юм. Ийм хүмүүсийн нэг болох Мераб Чухуаг тэнд “тэрслүү хэрэгтэн” хэмээн адлах богоод Мераб оороо Черкесүүд Грузин луу дайжин суурьшиж байгаатай огтхон ч санал нийлэхгүй байгаагаа илэрхийлж, “энэ бол Америкийн түрэмгийллийн уршигт тоглоом” гэдэг богоод Кавказад “Черкесийн соёлын тов”-ийг нээж, Оросын цэргүүдийг тэндээ урин санал бодлоо солилцдог ажээ. Харин Оросод байгаа Черкесүүд цомоороо л Кавказ дахь уугуул Черкесүүд нь Тбилис руу цутган орж байгааг буруушааж байна. Тэд одоо “Тусгаар Черкес улс” хэмээх байгууллагыг байгуулан тэмцэж байгаа богоод ийм нохцолд Орос улсыг түших нь цорын ганц зов зам хэмээн үзэж байгаа нийт Черкесийн цоонх хэсэг билээ.ÂÂ Дашрамд дурьдахад Зовлолтийн Засгийн газраас 1917 оны сүүлчээр Черкесүүдийг уугуул нутаг оронд нь суурьшуулах арга хэмжээ авсныг одоогийн Кавказ дахь Адыгечүүд болон Черкесүүд мон хорш зэргэлдээх ард түмнүүд юу гэж үзэж байгаа нь бас сонирхолтой билээ.

Бэлтгэсэн Дмитрий СОКОЛОВ

(“Дэлхий ба бид” /Мир и мы/ сайтын мэдээллийг ашиглав)

Орчуулсан Г.ТӨРМӨНХ

Кавказийн үймээн - III

Бичсэн туруу

2017 оны 6-р сарын 26, Даваа гариг, 16:59
